



ЁС ЗҮЙН ХОРООДОД

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11,
Утас: 204218, Факс: 264460

2012.03.09 № 214
танай _____-ны № _____-г

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 3 дугаар хуралдаанаар "Ёс зүйн хариуцлагын жил"-ийн хүрээнд хийсэн ажлыг Төрийн албаны зөвлөлийн аймаг, нийсэл дэх болон яам, агентлагийн дэргэдэх салбар зөвлөлүүд болон бусад төрийн байгууллагын ёс зүйн хороодоос ирүүлсэн мэдээ, тайланг хэлэлцэв.

Ёс зүйн хариуцлагын жилийн хүрээнд хийсэн ажлыг авч үзвэл.

- Улсын хэмжээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд 618 Ёс зүйн хороо байгуулагдан тэдгээр хорооны бүрэлдэхүүнд 2490 төрийн албан хаагч, 8 иргэдийн төлөөлөл орж ажиллаж байна.
- Төрийн албаны зөвлөлийн ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Сургалт, судалгаа зөвлөх үйлчилгээний нэгж болон Салбар зөвлөл, төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос 2011 онд ёс зүйн чиглэлээр нийтдээ 47 сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж 4404 /давхардсан тоогоор/ төрийн албан хаагч хамрагдсан байна.
- "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн ёс зүйн хороо ёс зүйн зөрчлийн тухай мэдээг төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн хороодоос хагас, бүтэн жилээр нэгтгэн авч үзэхэд, 2011 онд нийт 244 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэснээс Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэхээр дүгнэлт гаргасан 224, ёс зүй зөрчсөн гэх үндэслэлгүй гэж үзсэн 20 тохиолдол байна. Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэлээр нь авч үзвэл:
 - Гомдлоор – 51
 - Мэдээллээр – 11
 - Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр – 2
 - Ёс зүйн хорооны санаачилгаар – 24
 - Байгууллагын удирдлагын шийдвэрээр – 156

Эдгээрээс удирдах албан тушаалтны ёс зүйн 13 зөрчлийг хянан шийдвэрлэснээс Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэхээр дүгнэлт гаргасан 9, ёс зүй зөрчсөн гэх

үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн 4 байна. Удирдах албан тушаалтны ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэлээр нь авч үзвэл:

- Гомдлоор - 7
- Байгууллагын удирдлагын шийдвэрээр – 6 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэжээ.

Төрийн захиргааны албан хаагчийн Ёс зүйн зөрчил анх удаагаа гаргасан 228 албан хаагч, давтан гаргасан 16 албан хаагч байна.

Гэвч “Ёс зүй-хариуцлагын жил”-ийн хүрээнд хийх тодорхой төлөвлөсөн ажилгүй, холбогдох журмын дагуу дэргэдээ төрийн албан хаагчдын /хамт олны/ саналыг үндэслэн Ёс зүйн хороогоо байгуулаагүй, байгуулсан ч ёс зүйн зөрчлийн шинжтэй эсэхийг ялгахгүйгээр зөрчил бүгдийг ёс зүйн хороогоор хэлэлцүүлэхийг урьтал болгодог, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх харьяаллыг будлиулсан, Ёс зүйн хорооноос гаргасан дүгнэлт нь хууль зүйн үндэслэл муутай, ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хугацаанд нь ирүүлээгүй зэрэг дутагдал цөөн боловч гарлаа.

Төрийн байгууллагуудаас “Ёс зүй-хариуцлагын жил”-д зохион байгуулсан ажлын тайлан болон Ёс зүйн хороодоос хянан шийдвэрлэсэн зөрчлийн байдалд дүгнэлт хийж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх, гомдол, мэдээллийн мөрөөр хянан шалгаж, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ тайланг журамд заасан хугацаанд үнэн зөв гаргаж ирүүлэх чиглэлээр нийт төрийн байгууллагын ёс зүйн хороодод дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.2, 2.3-т заасны дагуу Ёс зүйн хороо байгуулаагүй байгаа газрууд хамт олны саналыг үндэслэн Ёс зүйн хороог байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх, хамт олны саналыг үндэслэл болгоогүй, удирдах бүрэлдэхүүнээр ярилцаж тохиролцох хэлбэрээр байгуулсан Ёс зүйн хороодыг татан буулгаж, журамд заасныг баримтлан шинээр байгуулах;

2.Холбогдох дүрэм, журмуудыг сайтар судалж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулахдаа Ёс зүйн хороодын дарга, гишүүдийн ёс зүйн тухай ойлголт, түүний дотор төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэгийг улам баяжуулах, ёс зүйн зөрчлийг бусад, ялангуяа сахилгын зөрчлөөс ялгаж зааглах чиглэлээр төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад системтэй сургалт зохион байгуулах;

3.Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, дүгнэлт гаргахдаа зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэн, Төрийн албаны тухай хуулийн болон “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн аль зүйл, заалтыг зөрчсөн болох, тэр нь ямар нотлох баримтаар тогтоогдож байгаа зэргийг нарийвчлан

зааж, ТАТХ-ийн аль зүйл, заалтыг баримтлан ямар арга хэмжээ авахуулахаар санал болгож байгаа, эсвэл ёс зүйн зөрчил биш гэдэг нь ямар нотлох баримтаар тогтоогдсоныг тодорхой зааж өгч байх;


4.2012 ондоо ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөхдөө "Монгол Улсын Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл"-ийг баримталж, хэвшүүлэх, сурталчлах, тайлбарлан таниулах, үзүүлэн таниулах материал бэлтгэж тараах, төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэгийг шалгах сорилтын тест, кейс боловсруулж, тодорхой хугацаанд шалгаж байх, албан хаагчдын дунд гарч болзошгүй нийтлэг ёс зүйн зөрчлүүдийн талаар хэлэлцүүлэг хийх.

1. Ёс зүйн зөрчлийн хагас болон бүтэн жилийн мэдээг дээрх журамд заасан харьяаллын дагуу заасан хугацаанд гаргуулан нэгтгэж, yoszui@csc.gov.mn хаягаар тогтмол ирүүлж байх;
2. Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд 14 хоногийн дотор Төрийн албаны зөвлөлийн ёс зүйн хороонд албан бичгээр болон yoszui@csc.gov.mn хаягаар хүргүүлэх;
3. Ёс зүйн чиглэлээр хийсэн ажил болон холбогдох эрх зүйн актууд, гарын авлага материалын талаар өөрийн байгууллагын вэйб хаяг, мэдээллийн самбар зэргээр олон нийтэд танилцуулах, сурталчилж ажиллах;
4. "Төрийн удирдах албан тушаалтны манлайлын жил"-ийн хүрээнд удирдах албан тушаалтны ёс зүйн сургалт, зөвлөгөөн, харилцан мэдлэг, мэдээллээ солилцох уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн ажлыг зохион байгуулах.

Энэхүү зөвлөмжийг аймаг дахь Салбар зөвлөлүүд өөрийн аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ёс хороодод хүргүүлж хариуг тус Зөвлөлд ирүүлнэ үү.

Жич: Төрийн албан хаагчийн ёс зүй, холбогдох эрх зүйн актуудын талаар заавар зөвлөгөө болон өөрийн байгууллагын санал хүсэлтийг 264493, 265045 утсаар болон yoszui@csc.gov.mn хаягаар ирүүлэх боломжтой.





Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ